



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Барилга байгууламж нийслэлийн
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан нийт 1,451,848,860.00 (Нэг тэрбум дөрвөн зуун тавин нэгэн сая найман зуун дөчин найман мянга найман зуун жар) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1118101135

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн
111... дүгээр тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	75 дугаар цэцэрлэгийн барилга	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 7 дугаар хороолол /14182/, Алтайн гудамж 263 тоот	2024	2024	1,451,848,860.00	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
НИЙТ ДҮН					1,451,848,860.00	